

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.Нямбаатар
Х.НЯМБААТАР
2024 оны 04 дугаар сарын 25 -ны өдөр

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ГҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Г.Мөнхбаатар
Г.МӨНХБААТАР
2024 оны 04 дугаар сарын 22 -ны өдөр

**ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН БОХИРДЛЫН ТАРХАЛТЫН
СУДАЛГААГ ХИЙХ, БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ
АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	<ul style="list-style-type: none">- Газрын тухай хууль;- Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”;- “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого 9.2.1.2. дахь зорилт;- “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 6.2. дахь зорилт;- “Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ий 258 дахь зорилт;- “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”- ний 5.2.6 дахь зорилт;- Нийслэлийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө.
2.	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Энэхүү ажлын зорилго нь нийслэлийн хот, тосгон, бусад суурины газрын мониторингийн 112 цэгт хүнд металлын бохирдлын тархалтын хил заагийг тодорхойлж, талбайн хэмжээг тогтоон зураглах, хөрсний бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээний талаар санал, зөвлөмж, арга зүй боловсруулахад оршино.
3.	Хамрах хүрээ	Нийслэлийн хот, тосгон, бусад суурины газрын мониторингийн 112 цэгт.
4.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 6 сарын хугацаанд.
5.	Ажлын иж бүрдэл	Тус ажлын тайланг цаасан болон тоон хэлбэрээр боловсруулах бөгөөд тоон хэлбэрээр дараах байдлаар захиалагчид хүлээлгэн өгнө. Үүнд: 1. Нийслэлийн хот, тосгон бусад суурины газрын мониторингийн 112 цэгийн хөрсний бохирдлын тархалтын хил заагийг тодорхойлсон ажлын тайлан (.....tailan_doc, pdf);



		<ol style="list-style-type: none"> 2. Хөрсний бохирдлын тархалтын хил заагийг тодорхойлох арга зүй (.....arga_zui_doc, pdf); 3. Хөрсний бохирдлын тархалтын хил заагийг тогтоон зурагласан тоон мэдээлэл, мэдээллийн сан (....._shp, mxd, бусад); 4. Хөрсний бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх хамгаалах аргачлалын санал, зөвлөмж (.....zuvlumj_doc, pdf); 5. Хавсралт материалд: <ul style="list-style-type: none"> - Хээрийн судалгаа, хөрсний дээж, зүсэлтийн зураг (Тухайн орчныг зурагт сайтар тусган харуулсан байна.) - Тоон мэдээллийг нэгтгэсэн дэлгэрэнгүй хүснэгт; - Магадлан итгэмжлэгдсэн хөрсний лабораторийн шинжилгээний дүн; - ArcGIS болон бусад программ хангамжийн ажлын файл; - Судалгаанд ашигласан арга, аргачлалын жагсаалт
6.	Гүйцэтгэх ажлын үе шат, хэмжээ	<p>Тус ажлыг дараах үе шаттайгаар гүйцэтгэнэ. Үүнд:</p> <p>Бэлтгэл ажил:</p> <ul style="list-style-type: none"> - Өмнө нь хийгдсэн хөрсний бохирдлын судалгааны ажлын тайлан, бохирдолд өртсөн цэгийн байршлын талаарх судалгаа, мэдээллийг холбогдох газраас авах; - Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөрсний бохирдлыг бууруулахтай холбоотой журам, заавар, аргачлал, стандартуудыг судлах; - Олон улс болон дотоодод хэрэглэгддэг хөрсний бохирдлын тархалтын хил заагийг тогтоох арга, аргачлал, стандартын талаар судлах; - Судалгааны арга зүй боловсруулах; <p>Хээрийн судалгаа:</p> <ul style="list-style-type: none"> - Хөрсний бохирдолтой цэгээс давтан дээж авч хөрс судлалын магадлан итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх; - Тухайн цэгийн ойролцоох нэгж талбарын газар ашиглалтыг бодитоор судлан тодорхойлох; - Хөрсний бохирдол үүсгэгч хүчин зүйлсийг тогтоох; <p>Материал боловсруулах:</p> <ul style="list-style-type: none"> - Хөрсний шинжилгээний дүнг нэгтгэх, бохирдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй батлагдсан арга зүй (PI ба PLI) ашиглан 2-оос доошгүй үзүүлэлтээр (I geo, RI, нянгийн бохирдол) үнэлэх. - Хөрсний шинжилгээний дүнд үндэслэн ArcGIS болон бусад шаардагдах программ хангамжийг ашиглан хөрсний бохирдлын тархалтын хил заагийг бодитоор тогтоон зураглах; - Тухайн орчны газар ашиглалтын байдал болон хөрсний бохирдлын хамаарлын судалгаа гаргах;



		<ul style="list-style-type: none"> - Хөрсний бохирдлын тархалтын хил заагийг тогтоож нөхөн сэргээх арга хэмжээ авахад шаардагдах төсөв, багаж хэрэгслийн талаар нарийвчилсан судалгаа гаргах; - Хөрсний бохирдлын тархалтын хил заагийг тогтоох, нөхөн сэргээх, хөрс хамгаалах чиглэлээр арга зүй боловсруулах; - Хөрсний бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, хамгаалах бодит туршлага, жишиг арга хэмжээний талаар судлан цаашид хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах.
7.	Тавигдах шаардлага, ажлын туршлага	<ul style="list-style-type: none"> - Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны болон газрын кадастрын судалгаа, газар зохион байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээд; - Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага; - Судалгаа шинжилгээний байгууллага, төв; - Эрдэм шинжилгээний хүрээлэн; - Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд түншлэл хэлбэрээр оролцож болно.
8.	Техникийн шаардлага	<ul style="list-style-type: none"> - Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолоор батлагдсан “Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоо”; - Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан “Хот, тосгон, бусад суурины газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын аргачилсан заавар”; - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны А/306 дугаар тушаалаар батлагдсан “Хот, тосгон, бусад суурины газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны мэдээллийн сангийн загвар”; - Байгаль хамгаалал, хөрс шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 3298-90; - Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019; - Газар зүйн мэдээллийн системийн ArcGIS программ хангамжийг ашиглан тоон зургийг боловсруулах;



9.	Ажлын шалгалт хяналт,	<ul style="list-style-type: none"> - Захиалагчийн хяналтын зардлыг нийт үнийн дүнгийн 5 (таван) хувиар тооцно. - Захиалагчийн хяналтыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Газрын мониторингийн хэлтэс, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны мониторингийн албан хаагчид хийнэ. - Захиалагч ажил шалгасан акт гаргаж, хяналт тавьж ажиллана.
10.	Архивт хүлээлгэн өгөх материал	<ul style="list-style-type: none"> - Ажлын явцын үе шатны тайлан 1 хувь; - Ажлын эцсийн үе шатны тайлан, цаас болон тоон хэлбэр /CD/-ээр – тус бүр 3 хувь; - Төлөөлөх талбайн нийслэлийн зураглалын тоон мэдээллийн сангийн эх код-3 хувь /CD/.
11.	Захиалагч байгууллага	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба.
12.	Санхүүжилт эх үүсвэр	Урсгал зардал, 70,000,000 (Далан сая) төгрөг.
13.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

